



ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын тайлан

**АЙМАГ, СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬ
ЗОХИОН БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДОН УЛСЫН ТӨСВӨӨС
САНХҮҮЖҮҮЛСЭН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛД АУДИТ ХИЙХ**

**Сонгуулийн зардлыг хяналтгүй, зардал хооронд
гүйлгэн зарцуулсан байна.**

**Чойр хот
2020 он**

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн: Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар Дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа Аудитын менежер Г.Наранбаяр Ахлах аудитор Ц.Батсайхан Аудитор Б.Анхтуяа 2020 оны 11 дүгээр сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70543179 дугаарын утсаар харилцана уу. ХАЯГ: Аймгийн Засаг даргын тамгын газрын байр, 2 дугаар давхар, 209 тоот	Товчилсон үгийн тайлбар Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй БҮЛЭГ 1. Орон нутгийн ИТХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилсан байна. 1.1 Улсын төсвөөс нийт 83,324.1 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна..... 6 1.2 Сонгуулийн хороодод зардлын төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна. 6 БҮЛЭГ 2. Улсын төсвөөс олгосон зардлыг хяналтгүй, батлагдсан төсвийн дагуу зарцуулаагүй байна.....6 2.1. Батлагдсан төсвийг хяналтгүй зарцуулсан байна..... 6 2.2 Батлагдсан зардлын зарим нэр төрлийг гүйлгэн зарцуулсан байна... 7 2.3. Засгийн газрын нөөц хөрөнгөөс олгосон бараа материалыг зориулалтын дагуу зарцуулсан байна.. 9 2.4. Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй байна..... 9 Дүгнэлт Зөвлөмж Холбогдох байгууллагын санал Холбогдох байгууллагын саналд хийсэн тайлбар Хавсралтууд
---	--

Товчилсон үгийн тайлбар

[illegible]

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2019 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/53 дугаар тушаал, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

2. Аудитын зорилт:

Орон нутгийн ИТХ-ын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд дүгнэлт гаргаж, аймгийн Сонгуулийн хороо болон холбогдох байгууллагад танилцуулж, иргэд олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

3. Аудитын хамарсан хүрээ:

Аудитад аймаг, сумдын сонгуулийн хороо, аймгийн Цагдаагийн хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс зэрэг байгууллагуудыг хамруулан холбогдох анхан шатны баримт, тайлан мэдээ, судалгаанд тулгуурлан хийж гүйцэтгэлээ.

4. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж, (АДБОУС 3000-3100), Гүйцэтгэлийн болон Санхүүгийн аудитын журмыг ашиглан асуулга, лавлагаа авах, сонгууль зохион байгуулсан тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, тулган баталгаажуулах зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ, аудитын судалгаа, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт гаргалаа.

5. Аудит хийх багийн бүрэлдэхүүн:

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хийж, ахлах аудитор Ц.Батсайхан, аудитор Б.Анхтуяа нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

6. Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл

Аудитын тайлан нь аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох байгууллагын санал, түүнд хийсэн тайлбар, хавсралт гэсэн бүтцээр үндсэн зорилтын дагуу бичигдсэн.

7. Хүндрэл бэрхшээл

Аудитын явцад хүндрэл бэрхшээл гараагүй.

8. Үндсэн мэдээлэл

Орон нутгийн ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулийг 10 хэсэг, нийт 84 суудлын төлөө аймагт 3 нам, 2 бие даагч, суманд 2 нам, нийт 170 нэр дэвшигч өрсөлдсөн байна.

Орон нутгийн ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахтай холбоотой аймаг, сумдын сонгуулийн хороод улсын төсвөөс 70,855.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 69,454.7 мянган төгрөгийг зарцуулж, 1,400.3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуулийг зохион байгуулахад нийт 180 төрийн албан хаагч ажилласан байна.

Орон нутгийн ИТХ-ын 2020 оны ээлжит сонгуульд 10,527 сонгогч санал өгөхөөс 6,883 сонгогч саналаа өгч сонгуулийн ирц 65.3%-тай оролцсон байна

Бүлэг 1

Орон нутгийн ИТХ-ын сонгуульд улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлыг хууль, журам, зориулалтын дагуу төлөвлөж, хуваарилсан байна.

1.1 Улсын төсвөөс нийт 83,324.1 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Орон нутгийн ИТХ-ын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс аймаг, сумдын сонгуулийн хороонд 70,855.0 мянга, Улсын бүртгэлийн хэлтэст 10,284.1 мянга, аймгийн Цагдаагийн хэлтэст 2,185.0 мянга, нийт 83,324.1 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

1.2 Сонгуулийн хороодод зардлын төсвийг үндэслэлтэй хуваарилсан байна.

Аймгийн ИТХТ-ийн 2020 оны 46 дугаар тогтоолоор аймгийн сонгуулийн хороог 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Орон нутгийн ИТХ-ын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын төсвийг анх 6,258.0 мянган төгрөгөөр баталсан боловч зардлыг сонгуулийн үе шатаар төлөвлөн СЕХ-оос 5 удаа тодотгож, нийт 70,855.0 мянган төгрөгөөр баталсан байна

СЕХ-ноос аймгийн сонгуулийн хороонд 21 нэр, төрлөөр 70,855.0 мянга, аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст 9 нэр, төрлөөр 10,284.1 мянга, Цагдаагийн хэлтэст 2 нэр, төрлөөр 2,185.0 мянга, нийт 83,324.1 мянган төгрөгийн зардлыг тус тус сонгогчийн болон сумын сонгуулийн хорооны тоонд үндэслэн хуваарилсан байна.

Бүлэг 2

Улсын төсвөөс олгосон зардлыг хяналтгүй, батлагдсан төсвийн дагуу зарцуулаагүй байна.

2.1. Батлагдсан төсвийг хяналтгүй зарцуулсан байна.

Орон нутгийн 2020 оны ИТХ-ын ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс сонгуулийн хороодод олгосон 70,855.0 мянган төгрөгийн санхүүжилтийг зарцуулахдаа сумдын сонгуулийн хороод дараах зөрчил дутагдал гаргасан байна. Үүнд:

- Сүмбэр сумын сонгуулийн хороо нь аймгийн сонгуулийн хорооноос сумын сонгуулийн хорооны унааны зардалд 375.0 мянган төгрөгийг баталж өгсөн байхад гүйцэтгэлээр 1,422.0 мянган төгрөгийг зарцуулж, 1,047.0 мянган төгрөгийг илүү зарцуулсан байна.
- Шивээговь сумын сонгуулийн хороо нь унааны зардал 20.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй зарцуулсан байна.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1,13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сонгуулийн ерөнхий хорооны 2016.03.02-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Аймгийн Сонгуулийн хороо нь сумдад олгосон зардлын санхүүжилтийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллаагүй байна

2.2 Батлагдсан зардлын зарим нэр төрлийг гүйлгэн зарцуулсан байна.

Говьсүмбэр аймгийн хэмжээнд 2020 оны орон нутгийн ИТХ-ын ээлжит сонгуульд нийт 10,527 сонгогчид санал өгөхөөр бүртгэгдсэн бөгөөд сонгуулийн үйл ажиллагаанд зориулж улсын төсвөөс 70,855.0 мянган төгрөгийг авч, гүйцэтгэлээр аймгийн сонгуулийн хороо 36% буюу 25,075.0 мянга, Сүмбэр сумын сонгуулийн 37% буюу 25,811.0 мянга, Баянтал сумын сонгуулийн хороо 13% буюу 8,786.7 мянга, Шивээговь сумын сонгуулийн хороо 13% буюу 9,782.0 мянга, нийт 69,454.7 мянган төгрөгийг зарцуулж, 1,400.3 мянган төгрөгийг СЕХ-нд буцаан төвлөрүүлсэн байна.

Нийт 10,527 сонгогчдоос 6,883 сонгогч буюу 65.3 хувь нь санал хураалтад оролцож, улсын төсвөөс олгосон санхүүжилтийг 98.0%-ийг зарцуулсан байна.

Улсын төсвөөс аймаг, сумдын сонгуулийн хороодод олгосон санхүүжилтийн төсөв, гүйцэтгэлийг зардлын нэр, төрлөөр хүснэгтээр харуулбал

				/мян.төг/
№	Зардлын нэр	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт, хэмнэлт
1	Маягт хэвлүүлэх зардал	150.0	150.0	0.0
2	Үнэмлэх хэвлэх зардал	540.0	540.0	0.0
3	Сонгуулийн байгууллагын ажилтны сургалтын зардал	1,658.0	1,658.0	0.0
4	МТБ-ийн гишүүн, даамлын сургалтын зардал	1,110.0	1,110.0	0.0
5	Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хорооны бичиг хэргийн зардал	850.0	850.0	0.0
6	аймаг, нийслэл, сум дүүргийн сонгуулийн хорооны шуудан холбооны зардал	950.0	950.0	0.0
7	Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны унааны зардал	1,975.0	3,022.0	-1,047.0
8	Сум, дүүрэг, хэсгийн хорооны унааны зардал	4,500.0	3,453.0	1,047.0
9	Хэсгийн хорооны бичиг хэргийн зардал	800.0	800.0	0.0
10	Хэсгийн хорооны шуудан хорооны шуудан холбооны зардал	1,000.0	1,000.0	0.0
11	Санал авах байр, Төрийн далбаа бэлтгэх зардал	2,200.0	2,200.0	0.0
12	Сурталчилгааны зардал	3,000.0	3,000.0	0.0
13	Саналын хуудас, ИСР төхөөрөмж авах хүлээлгэн өгөх зардал	4,278.0	4,278.0	0.0
14	МТБ-ийн зардал	390.0	390.0	0.0
15	Сонгуулийн автоматжуулсан системийн зардал / эрчим хүчний эх үүсгэвэр бэлтгэх/	350.0	349.7	0.3
16	Томилолтын зардал	2,600.0	2,600.0	0.0
17	Унааны зардал / туршилтын болон санал авах өдрийн мэдээ дамжуулах/	220.0	220.0	0.0

18	Болзошгүй зардал	1,000.0	1,000.0	0.0
19	Аймаг, нийслэл, сум дүүрэг, хэсгийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардал	37,230.0	35,830.0	1,400.0
20	МТ-ийн багийн гишүүн, санал авах байрны даамлын урамшуулал, хоолны зардал	5,400.0	5,400.0	0.0
21	Сонгуулийн тайлан тушаах	654.0	654.0	0.0
Нийт дүн		70,855.0	69,454.7	1,400.3

Хүснэгтээс харахад: СЕХ-ны 2020 оны 3/465 дугаар албан бичгийн 1 дүгээр хавсралтаар аймгийн сонгуулийн хорооны гишүүн нягтлан бодогч, бичиг хэргийн ажилтны үүргийг давхар гүйцэтгэж байгаа бол урамшуулал, хоолны зардлыг эдгээр хүмүүст давхардуулан олгохгүй гэсний дагуу аймаг, нийслэл, сум дүүрэг, хэсгийн хорооны гишүүний урамшуулал, хоолны зардлыг 1,400.0 мянга, Баянтал сумын сонгуулийн хороо нь сонгуулийн автоматжуулсан системийн зардлыг 0.3 мянга, нийт 1,400.3 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

Харин Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2020.09.02-ны өдрийн А/1304 тоот тушаалын 7 дугаар хавсралтаар сонгууль зохион байгуулах зардлын төсвийг аймагт 9 нэр, төрлөөр 10,284.1 мянган төгрөг баталсныг гүйцэтгэлээр 100% зарцуулсан боловч зарим зардлыг зардал хооронд гүйлгэн зарцуулсан байна.

Сонгуулийн зардлын төсөв, гүйцэтгэлийг зардлын нэр, төрлөөр хүснэгтээр харуулбал:

/мян.төг /				
№	Зардлын нэр	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
1	Улсын бүртгэлийн байгууллагын ажилтан, итгэмжлэгдсэн ажилтны болон гэрээт ажилтны мөнгөн урамшуулал, хоол, унааны зардал	843.8	843.8	0.0
2	Итгэмжлэгдсэн ажилтан	4,620.0	4,620.0	0.0
3	Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, хүргэхэд шаардагдах зардал	415.3	415.3	0.0
4	Сонгогчдын нэрийн жагсаалт хэвлэх, хүргэх зардал	383.0	383.0	0.0
5	Сургалт зохион байгуулах болон түүнтэй холбогдон гарах бусад зардал	1,045.0	1,228.0	-183.0
6	Бусад сургалтын зардал	143.0	0.0	143.0
7	Сонгогчийг бүртгэх таних техник хэрэгслийг хэвийн ажиллагааг хангаж ажиллах шуурхай багийн зардал	1,104.0	1,104.0	0.0
8	Техник хэрэгсэл тээвэрлэх зардал	1,600.0	1,600.0	0.0
9	Шуурхай багийн зардал	130.0	90.0	40.0
Нийт дүн		10,284.1	10,284.1	0.0

Хүснэгтээс харахад: сургалтын бусад зардлыг 143.0 мянга, шуурхай багийн зардлыг 40.0 мянга, нийт 183.0 мянган төгрөгөөр хэмнэсэн боловч сургалт зохион байгуулах болон түүнтэй холбогдон гарах бусад зардалд 183.0 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сонгуулийн ерөнхий хорооны 2016.03.02-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор баталсан “Сонгуулийн хороодод төсөв хуваарилах, зарцуулах, түүнд хяналт тавих, тайлан гаргах тухай журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.3. Засгийн газрын нөөц хөрөнгөөс олгосон бараа материалыг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Улсын онцгой комиссоос 388 ширхэг гар ариутгагч, 360 хос сонгуулийн ажилтны нэг удаагийн бээлий, 8,684 хос сонгогчийн бээлий зэрэг нийт 9,432 ширхэг материалыг аймгийн сонгуулийн хороо хүлээн авч 7,752 ширхгийг нь сонгуулийн үйл ажиллагаанд зарцуулсан бөгөөд үлдэгдэл бараа материал болох 1,450 хос сонгогчийн бээлий, 230 ширхэг гар ариутгагчийг аймгийн Онцгой байдлын газарт хүлээлгэн өгсөн байна.

2.4. Сонгуулийн зардлын зарцуулалтад хяналт тавьж ажиллаагүй байна.

Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороодод олгосон зардлын санхүүжилтэд хяналт тавьж ажиллаагүйгээс нийт 1,067.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

1. Сонгууль зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс аймаг, сумдын сонгуулийн хороонд олгосон зардлын санхүүжилтийг 1,400.3 мянган төгрөгөөр хэмнэж, төсвийг буцаан төвлөрүүлсэн сайн талтай байна.
2. Аймгийн сонгуулийн хороо нь сумдын сонгуулийн хороодод олгосон зардлын санхүүжилтэд хяналт тавьж ажиллаагүйгээс батлагдсан төсвийн зардлыг гүйлгэн зарцуулж, анхан шатны баримтыг дутуу бүрдүүлсэн байна.
3. Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь сонгуулийн үйл ажиллагааны зарим зардлыг зардал хооронд гүйлгэн зарцуулсан байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО

42015 Чойр, Говьсүмбэр аймаг,
Утас/Факс: (976) 7054 3225

Холбогдох Н.Н. № 191
танай _____-ны № _____-т

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгууль зохион байгуулахтай холбогдон улсын төсвөөс санхүүжүүлсэн зардлын гүйцэтгэлд хийгдсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тайлангийн төсөлд өгөх саналгүй болно.

ДАРГА



ЖОЮУНБИЛЭГ

Н.Б. ах сайхан
Тайланг саарал
ордуулж, тайланг
байнгамжуулах
20/11

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Холбогдох байгууллагаас тайлангийн төсөлд санал ирээгүй тул тайланд өөрчлөлт ороогүй болно.